



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Жороо морин спортын орчин.
Сургалтад тавих шаардлага.**

MNS 6699 : 2017

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2017 он**

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон Улсын Стандартчиллын Байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж гишүүдийн 75%–иас доошгүй дэмжиж, зөвшилцсөн төслийг Стандартчиллын Үндэсний Зөвлөл (СҮЗ)–өөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Биеийн тамир, спортын газраас санаачлан Монголын үндэсний жороо морин спортын холбоо эрхлэн боловсруулсан.

СХЗГ-ын стандартын шинжээч Н.Батжаргал “Монгол улсын стандартчиллын тогтоолын 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм MNS 1-2:2006” стандарттай нийцүүлэн хянав.

Стандартыг Биеийн тамир, спортын стандартачиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар 13348, ШХ-48

Утас: 266754, 263860,

Факс: (976-11) 458032

E-mail: standardinform@masm.gov.mn

Вэб сайт: www.estandard.mn,
www.masm.gov.mn

© СХЗГ, 2017

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандарчиллын Төв байгууллага)-т байна.

Оршил

Хүн төрлөхтөн арван мянган жилийн өмнөөс адууг гаршуулснаас хойш дэлхийн шинэ түүхийг бүтээхэд морь гэдэг амьтан ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Монгол үндэстний түүхийг бүтээхэд хүний үнэнч анд нөхөр болсон адууг төрийн сүлдэндээ залж, хийморь лундааг нь сэтгэлдээ дуудан хүндэтгэн дээдэлдэг, арчлан адгуулдаг ард түмэн билээ бид.

Өдгөө цагт дэлхий дээр олон төрлийн үүлдэр угсааны адууны омог сүрэг бий болсоны зэрэгцээ морин спорт нь олон хувилбараар хөгжиж байгаагийн нэг нь Монгол үндэстний бахархал чимэг, хурд, хүч, тансаг, эрх мэдлийн билэгдэл болсон Жороо морины уралдаан, тэмцээн билээ.

Монголоос 15 дахин бага газар нутагтай Исланд улс нь “Нисдэг жороо” /Flying race/ морины уралдаан, уналгын чиглэлээр аялал жуулчлалыг хөгжүүлжснээр нэг жилийн хугацаанд 1 сая орчим гадаадын жуулчдыг хүлээн авч, Америк, Швед, Герман, Франц, Норвеги руу жороо мориныг экспортод гаргаж үндэстний орлогод багагүй хувийг бүрдүүлж байх жишээ бага бус байна.

Монгол үндэстний уламжлалт баяр наадмын нэг төрөл хурдан морины уралдаанд Жороо морин спортын чиглэлийг орчин үеийн спортын шинэ түвшинд гаргах зорилгоор “Монгол жороо морь нийгэмлэг”-ийг уяач Д.Долгоржав агсаны санаачлагаар 1996 онд байгуулсан. Энэхүү үйл хэргийг үргэлжлүүлэх залгамж халаа болж “Монголын үндэстний жороо морин спортын холбоо” нь уралдааны зохион байгуулалт, маргаан будлиангүй, шударга шүүлттэй үлгэр жишээ спортын төрөл болгон хөгжүүлэхээр зорьдог.

Дээрх асуудлын хүрээнд бодит амьдралд гарсан алдаа дутагдалд дүгнэлт хийж, инноваци техник технологийн ололт амжилтыг хослуулсан судалгааг хийснээр энэхүү стандартыг боловсруулан гаргалаа.

Энэхүү стандартыг мөрдлөг болгон амьдралд бодитоор хэрэгжүүлж, хэвшил болгох нь Монгол үндэстний нэгэн бахархал болж, улс эх орондоо төдийгүй тив дэлхийн хэмжээнд монгол жороо морины үнэ цэнэ өсөн нэмэгдэж, бусдыг манлайлан торгон жолоог тив дэлхийн хэмжээнд өргөн өрсөлдөх спортын нэг төрөл болж хөгжинө гэдэгт итгэлтэй байна.

Дэмжлэг арга зүйн туслалцаа үзүүлсэн БСШУСЯ, Биеийн тамир спортын газрын хамт олон, эрдэмтэн судлаач профессор, доктор Я.Ганболд болон Зууны манлай уяач, Хөдөлмөрийн баатар, Гавьяат, Тод манлай уяач Д.Даваахүү нарт талархал илэрхийлье.

Эрхэм Та бүхнийг холбооны үйл ажиллагаанд хамтран оролцож, стандарт, дүрэм журмыг цаашид улам боловсронгуй болгоход санал бодлоо хуваалцаж, Монголын үндэстний жороо морин спортыг хөгжүүлэх, тив дэлхийд танигдах үйлсэд эвлэлдэн нэгдэх уриалгыг хүлээн авна уу.

Эрхэм Та бүхнийг хүндэтгэсэн,
Монголын үндэстний жороо морин спортын холбооны тэргүүн Д.Эрдэнэхуяг.

ГАРЧИГ

1	Зорилго	1
2	Хамрах хүрээ	1
3	Норматив эшлэл	1
4	Нэр томъёо тодорхойлолт	2
5	Ерөнхий шаардлага	3
6	Тэмцээний орчинд тавих шаардлага	4
7	Уралдааны талбай, талбарт тавих шаардлага	4
8	Тэмцээн уралдааны зохион байгуулалтад тавих шаардлага	6
9	Морь унаач, тамирчин, морьны хэрэгсэлд тавих шаардлага	7
10	Сургалтад тавих шаардлага	8
11	Дасгалжуулагчид тавих шаардлага	10
	Хавсралт (мэдээллийн)	11